

Даалгавар 1


Хүүхдүүд ээ, багш нь та нарт нэг дуу дуулж өгье. Анхааралтай сонсоорой /Багш хүүхдүүдэд дууг 2 удаа дуулж өгнө/.

Энэ дуунд гараагүй гурван юмыг зураг дотроос сонгож дугуйлаарай.

Маамуу нааш ир


Маамуу нааш ир, манайд хоёулаа тоглоё
Аав ээж хоёрын, авчирсан тоглоом бий шүү
Морь унаж давхия, машин барьж явъя
Ном сонин уншъя, ногоон модоо тарья

Маамуу нааш ир, манайд хоёулаа тоглоё
Ах, эгч хоёрын, авчирсан тоглоом бий шүү
Хүрэн баавгай хөтөлье, хүчит заанаа тууя
Хүүхэлдэйтэйгээ хамт хөөрхөн тоглоом тоглоё




Даалгавар 2

Болд аргал түүв. Аргалыг ямар дарааллаар түүсэн бол? Дарааллыг олж, хэд дэх нь болохыг зургийн доод талын дөрвөлжинд цэгээр тэмдэглээрэй.





Даалгавар 3.

Ид шидийн хайрцаг юмыг яаж өөрчилдгийг зүүн талын зурагт харуулжээ. Баруун талын зургийг ажиглаад зөв хариултыг дугуйлаарай.




Даалгавар 1

Хүснэгтэд цагаан, хар бөмбөлгүүд байрлуулсан байна. Хүснэгтийн хоосон хэсэгт ямар өнгийн бөмбөлгүүд байх вэ? Тохирохыг сонгож дугуйлаарай.




Даалгавар 2

Зураг дээрх хүүхэд бүрийн баруун тохойг дугуй дүрсээр, зүүн шилбийг гурвалжин дүрсээр тэмдэглээрэй.



Даалгавар 3.


3 хүүхэд нэг бөмбөгөөр тоглох бол зураг дээрх хүүхдүүд хэдэн бөмбөгөөр тоглох вэ? Хоосон нүдэнд бөмбөгний тоог цэгээр тэмдэглээрэй.



Даалгавар 4.


Дасгал- 1

Зураг даруулж байгаа амьтдыг араас нь харуулжээ. Аль зургийг дарсан болохыг дараах дөрвөн зургаас сонгоод дугуйлаарай.



Дасгал- 2

Энэ зургийг аль амьтан дарсан болохыг сонгоод, гурвалжингаар тэмдэглээрэй.



Даалгавар 5

Хүүхдүүд ээ, матрын зургийг сайн ажиглаарай. Доорхи дүрсүүдийг эвлүүлэхэд энэ зураг бүтнэ. Харин 1 дүрс илүү гарна. Түүнийг олж дугуйлаарай.

